

Living the Lotus 1

2024

Buddhism in Everyday Life

VOL. 220



PKK Сан Антонио

Living the Lotus Vol.220 (2024.01)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын
хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Sugina-
mi-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг тууцгааяа гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



«Бодь сэтгэлийг хөгжүүлэх» үйлд шамдах нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

“Бурханы номонд шамдах нь ачааг зөөх шар лугаа...”

Та бүхэнд шинэ оны мэнд дэвшүүлье. “Хаалга болгоны гадна өлгөсөн зулзган хуш мод хавар ирснийг илэрхийлнэ” хэмээх Сайгёо (1118–1190) ламтны шүлэг хүн бүрт хаврын урин цагийн мэдрэмжийг өгдөг. Шинэ оныг угтан үүдээ хуш модоор чимэх айл одоо цөөрсөн ч Япон орны энэхүү сэтгэл сэргэм уламжлал шиг өөдрөг, эрч хүчтэйгээр айлчлан ирж буй жилээ угтацгаая.

Бид бурханы сургаалаас суралцаж, хүнийхээ хувьд нэг алхам ч болтугай урагшлахыг хүсдэг. Энэ нь биелэгдэшгүй хүсэл биш юм. Бурхан багш шиг амьдрахсан хэмээн зорьж, сургаалыг хэрэгжүүлэхээр шамдах үед хүнийхээ хувьд өсөж, хөгжих баяр баясгаланг хэзээ ч байсан мэдэрч болдог хэмээн сургадаг.

Бурханы зам мөрөөр явах, сургаалыг хэрэгжүүлэхээр шамдах гэдгийг сонсохоор маш их хичээл зүтгэл гаргахгүй бол сайн хүн болж чадахгүй гэж бодох хүн цөөнгүй байдаг бололтой. Гэвч эртний “Нипада” сударт Шагжамүни бурхан “Сургаалыг хэрэгжүүлэхээр шамдах үйл нь ачаа зөөх шар шиг бөгөөд амар амгалангийн түвшинд биднийг хүргэдэг” хэмээн дурдсан байдаг. Ачаа зөөх шарыг төсөөлөн бодоход шаргуу, махруу, хатуужилтай гэхээс илүүтэй тууштай ачааг чирэх шарын дүр төрх, анжисаа чимээгүйхэн чирээд тариан талбайг хагалах дүр төрх санаанд бууна. Эндээс үлгэр жишээ аван бид ч яаралгүй гэхдээ амралгүй сургаал номоор дамжуулж зүрх сэтгэлийн талбайгаа боловсруулж, амьдралдаа яарч сандралгүй хэрэгжүүлэх чухал гэж бодон одоогоос 25 жилийн өмнө миний бие “бодь сэтгэлийг хөгжүүлэх” номоо хэвлүүлж байсан.

Номондоо ч дээрх нэг мөргийг танилцуулсан нь Шагжамүнигийн айлдсан ариун судрын шүлгээр дамжуулж, шашны урсгал, судрын ялгаанаас үл хамаарах нийтлэг зүйл, бурханы сургаалыг заах хүний амьдралын мөн чанарыг та бүхний хамтаар тунгаан бодохын тулд юм. Түүний дээр Шагжамүни бурханы бусдад түгээхийг хүссэн зүйлийг энгийнээр хүлээн авч, өдөр дутмын амьдралдаа хүчлэлгүй хэрэгжүүлэх нь амар амгаланд хөтлөх шамдалт юм болов уу гэж бодож байна.

Тэгвэл Шагжамүни бурхан юуг бусдад түгээхийг хүссэн юм болоо?

Тасралтгүй үргэлжлүүлэх нь

Үүсгэн байгуулагч “хүн бүр ижил”, бүгд нэгдмэл... энэ бол бурханы үндсэн үзэл санаа мөн гэж айлдсан байдаг. Үүнийг сайн ойлговол аливаа зүйлийг харах өнцөг өөрчлөгдөж, амьдралын хэв маяг ч өөрчлөгдөнө. Ийм бодолтой хүмүүс хорвоод олон болвол бүгд эв найрамдалтай амьдарч чадна. Бурханы сургаал бидэнд үүнийг л заах гээд байгаа юм. Жишээлбэл шашны урсгал, байгууллага өөр өөр байсан ч “бүх хүний амь нас ижилхэн үнэ цэнтэй, талархалтай”, “бүгд нэг “амь нас”-наас үүссэн анд нөхөд” гэсэн Шагжамүнигийн сургаал дээр нэгдэж, үүнийг хүмүүсийн зан ааш, онцлог чанарт тааруулан өөр өөрөөр илэрхийлсэн гэж би ойлгодог.

Соогошүү урсгалын Эйхэйжи сүмийн хамба лам асан Ямада Рэйрин багштан ингэж хэлсэн байдаг. “Зэн урсгалын Доогэн багштан юуг ч харсан, сонссон энэ нь “би” гэж хүлээж авдаг байсан гэдэг. (товчлол) Бид “бусад хүн” гэж ярьдаг бол Зэн багштан “бусад хүн бол би өөрөө” хэмээн хэлдэг байсан гэлцдэг. Гадны хүн бол гадны боловч үүнийг “надаас ялгаагүй” гэж мэдэрч, бусдын баяр баясал, уйтгар гунигийг ч “миний” баяр баясал, “миний” уйтгар гуниг” хэмээн тэмдэглэж, энэ л жинхэнэ “хүн төрөлхтөний зүй ёсны амьдрал” гэж хэлсэн.

Бурханы зам мөр дэх хатуу чанга үйл нь ч зам мөрт шамдах үйлдэл мөн боловч өдөр дутмын амьдралдаа аминч шунал, уур хилэн, атаа чөтөөнд сэтгэл автах бүрт “хүн төрөлхтөн бүгд ижил” “бүгд нэгдмэл” гэсэн сэтгэлийг маргалгүй санах нь бурханы зам мөрт шамдах үйл бөгөөд үүнийг тасралтгүй үргэлжлүүлэх нь хүн төрөлхтөн бидний хувьд зүй зохистой амьдрал, Шагжамүни бурханы хүссэн амьдралын замнал мөн гэж бодно. Энэ сэтгэл нь өдөр дутамдаа бидний санаатай, санаандгүй хэлсэн үг, үйлдлийг маань залруулах болтугай хэмээн бодь сэтгэлээ хөгжүүлэн, өдөр бүрийг эрүүл саруул, амгалан тайван амьдрахыг хүснэ.

<Косей> 2024 оны 1-р сарын дугаараас



Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Гишүүн болвол

Гурван эрдэнэ

Бурхан багш бидэнд “Мөргөлийн гурван эрдэнэ”-ийг нандигнан эрхэмлэхийг сургадаг. Энэхүү гурван эрдэнэ нь “Бурхан, ном, хувраг”-ийг хэлж буй бөгөөд бурхны гарамгай сайн шавь болохын үндэс буюу сэтгэлийн түшиг тулгуур юм.

Бурхан гэдэг нь Будда, шүтээн (Ялж төгс нөгчсөн дуусашгүй буян үйлдэгч номын хаан Шагжамүни) юм. Ном бол бурхны сургаал.

Хувраг бол сургаалыг дагаж, хэрэгжүүлдэг бурхны шавь бөгөөд номын анд ч гэж бас хэлдэг. Энэхүү мөргөлийн гурван эрдэнэд тулгуурлан сургаалыг хэрэгжүүлж чадвал аз жаргалтай амьдрах болно.



Бяцхан мэдлэг

“Бурхан, ном, хувраг” гэсэн “Мөргөлийн Гурван эрдэнэ”-д хувь заяагаа даатгахыг «Гурван эрдэнэд сүсэглэх» гэдэг. Энэ нь Буддын шашинтны үндсэн чанар бөгөөд Рисшо Косей Кай нийгэмлэг ч бас үүнийг эрхэмлэдэг юм.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Гишүүний тангараг



Гишүүний тангараг нь Рисшо Косей Кай-г үүсгэн байгуулсан үзэл санаа, зорилго, мөн гишүүн хүний баримтлах зарчмыг товчоор илэрхийлдэг.

Рисшо Косей Кай бүлгийн гишүүн Ялж Төгс Нөгчсөн түүнчлэн хутагт Шагжамунид итгэмүй. Хүндэтгэлт зохион байгуулагчийн буянаар авралын утгыг Бурхан багшийн номд үзмүй. Убаши нарт зориулан Бурханы номын сэтгэлийг түшин үнэн итгэл болоод шинжлэх ухааны замаар боди мөрөнд олон нугуудыг дагуулан гэр бүл, нийг гүрнээрээ энх амгалангийн туяат ертөнцийг байгуулахын тулд



бодисадвагийн үйл айлтгахын тулд биеэ зориулан өөрийн сэтгэлийг сайжруулахыг зүтгэюү.

Бяцхан мэдлэг

“Хэрэгжүүлэх ба суралцах зам” гэсний “Тёо буюу хэрэгжүүлэх” гэдэг нь Цагаан лянхуа судрын сургаалыг хэрэгжүүлэх гэсэн утгатай. Сургаалыг амьдрал дээр хэрэгжүүлж байж л та юуг илүү сайн суралцах ёстойгоо мөн сурахын ач холбогдлыг ойлгох болно. Суралцаад хэрэгжүүлэх, хэрэгжүүлээд суралцах нь яг л тэрэгний хоёр дугуй шиг салшгүй холбоотой зүйл юм.

Оны эхэнд “Өөрийн сэтгэлийг ариусгах” НЬ

Акагава Кэйичи

Та бүхэнд шинэ оны мэнд хүргэе!

Би “Хэлтсийн даргын булан”-г хөтөлж эхэлснээс хойш хэдийнэ 4 жил өнгөрчээ. Энэ жил ч гэсэн булангаараа дамжуулж буддын шашныг гүнзгийрүүлэн судалж, уншигч та бүхэнтэй харилцан яриагаа өрнүүлсээр байх болно.

Манай шашны байгууллага үүсч байгуулагдаад 60 жилийн ойгоо тохиолдуулан “Бодь сэтгэлийг хөгжүүлэх” гэсэн чиг шугамыг баримталж эхэлснээс хойш хорин таван жилийн хугацааг өнгөрүүлжээ. Энэ үг бол Шагжамүни будда амьд ахуйдаа нэгэн бяраманд хандан “Та газар хагалж хөрс боловсруулдаг бол би хүмүүсийн зүрх сэтгэлийн хөрсийг боловсруулдаг” гэж хэлсэн ярианаас үүдэлтэй. Нивано ерөнхийлөгч өнгөрсөн жилээс эхлэн айлдвартаа “Эрч хүчтэйгээр бурхны үйлд шамдах”-ыг онцолж сургасаар байгаа бөгөөд энэ нь сэтгэлээ сайгар боловсруулж хөгжүүлж байж л хэрэгжинэ гэдэгт би итгэлтэй байна.

Үүний тулд Бурхны шашинт сүсэгтэн бүхний сахивал зохих “Долоон буддагийн шүлэг”-т багтдаг “Сэтгэлээ ариусгах” үйлд анхаарлаа хандуулах хэрэгтэй юм. 2024 онд баялаг өөдрөг сэтгэлтэй байхын тулд бурхан багшийн хүслийн дагуу амьдарч байна уу эсвэл өөрийн хувиа хичээсэн сэтгэлгээндээ баригдсан байна уу гэдгээ өөрөөсөө асууж, хором мөч бүрт өөрчлөгддөг бодол сэтгэлээ дахин нэг удаа тунгаан бодмоор байна.

Буддын шашинтны хувиар сургаал номоо амьдралдаа хэвшүүлэн, тайван амгалан, итгэл найдвараар дүүрэн өдрүүдийг өнгөрөөхийн тулд та бүхэнтэй хамтдаа номын зам мөрөөр шамдах болно. Энэ жил ч бас тусалж дэмжээрэй.




2023 оны 12 сарын 17 нд Сан-Франциско сүмийн тэргүүнийг томилох ёслол дээр гишүүдийн хамтаар (голын эгнээний дунд сууж байгаа нь Акагава Кэйичи)

Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp